



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/310

Булган сум

“Эрч булаг лайн” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 37 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвийн цэвэрлэх байгууламж (Сэлэнгэ сум)-ийн зураг төсөв боловсруулах ажлыг 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгөөр “Эрч булаг лайн” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Эрч булаг лайн” ХХК-ийн захирал (Э.Янжинлхам)-д үүрэг болгосугай.

3.Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг Аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д даалгасугай.

4.Дээрх ажил шаардагдах зардлыг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний “Сумын төвийн цэвэрлэх байгууламж (Сэлэнгэ сум)” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугас Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010453